



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 03 дугаар сарын 29

№ 01/60

Улаанбаатар хот

ГАГ-2018-02-ГА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дараах зөрчил илэрлээ.

Эрүүл мэндийн яам Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн цогцос хэдгалах байрны барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч "Жу Жу" ХХК-тай 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 1,136,428,230.0 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан байна. Гүйцэтгэгч компанийн 2017 онд хийсэн ажлын гүйцэтгэл 391,772,315.0 төгрөг буюу 34 хувьтай байхад Эрүүл мэндийн яам гүйцэтгэгчийн хийгдээгүй ажилд бодит бус гүйцэтгэл баталгаажуулж 1,136,428,230.0 төгрөг буюу 100 хувийн санхүүжилтийг улсын төсвөөс олгож, гүйцэтгэгчид 391,772,315.0 төгрөг, эрүүл мэндийн яамны барьцаа хөрөнгийн дансанд 744,655,915.0 төгрөгийг байршуулсан нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.3-т "Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, бүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна.", 4.11-т "Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралт, их засварын ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргана.", 5.4-т "Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын санарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.



Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ..." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**



1. Эрүүл мэндийн яамны барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 744,655,915.0 /долоон зуун дөчин дөрвөн сая зургаан зуун тавин таван мянга есөн зуун арван тав/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

Акт, албан тушаалагчийн биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаг тавьсан албан тушаалагчид, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

2. Актын биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганцэцэг, Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга Д.Нарантуяа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Өнөболд нарт хариуцуулав.

АКТЫГ

ӨГСӨН:
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ДАВААНЯМ
АУДИТОР

Б.ХАШ-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ГАНЦЭЦЭГ
ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНТУЯА
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ӨНӨБОЛД

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 03 дугаар сарын 29

№ 01/59

Улаанбаатар хот

ГАГ-2018-02-ГА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дараах зөрчил илэрлээ.

Эрүүл мэндийн яамнаас худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй шууд гэрээ байгуулсан Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч "Одкон холдинг" ХХК-д шүүхийн шийдвэр гараагүй байхад Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Хөрөнгө шийдвэрлэх тухай" А/516 дугаар тушаалыг үндэслэн Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийг нээж, эрүүл мэндийн яамны барьцаа хөрөнгийн дансанд 1,028,306,930.0 /нэг тэрбум хорин найман сая гурван зуун зургаан мянга есөн зуун гуч/ төгрөгийг байршуулсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.20-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ..." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Эрүүл мэндийн яамны барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 1,028,306,930.0 /нэг тэрбум хорин найман сая гурван зуун зургаан мянга есөн зуун гуч/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганцэцэг, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Д.Нарантуяа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Өнөболд нарт хариуцуулав.

өгссөн:
 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ
 АУДИТОР *[Signature]* М.ДАЛАНЯМ
 АУДИТОР *[Signature]* Б.ХАЦ-ЭРДЭНЭ

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
 НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
[Signature] Д.ГАНЦЭЦЭГ
 ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА
[Signature] Д.НАРАНТУЯА
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
 ДАРГА
[Signature] Д.ӨНӨБОЛД

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллага тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажиллаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харилцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 дугаар сарын 29

№ 01/104

Улаанбаатар хот

ГАТ-2018-02-ГА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дараах зөрчил илэрлээ.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч солигдсон боловч өмнөх гүйцэтгэгчтэй гэрээг дүгнэж акт үйлдээгүй, хийсэн ажлын тоо хэмжээг төсөвтэй нь тулгаж илүү төлсөн санхүүжилтийн зөрүүг гаргаж, нэмжлээгүй байна. Үүнд:

- Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний өмнөх гүйцэтгэгч "Лайт капитал хаус" ХХК-нд 2,524.4 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 87.1 хувийг олгосон байхад барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувьтай гэрээ цуцлагдсан,
- Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээний өмнөх гүйцэтгэгч "Гуулин тал" ХХК-нд 469.8 сая төгрөг буюу 100 хувийн санхүүжилт олгосон байхад барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувьтай гэрээ цуцлагдсан,
- Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд сум/ төсөл, арга хэмжээний өмнөх гүйцэтгэгч "Монинжбар" ХХК-нд 1,285.0 сая төгрөг буюу 100 хувийн санхүүжилт олгосон байхад барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувьтай гэрээ цуцлагдсан,
- Эрүүл мэндийн төвийн барилга /Дундговь, Дэлгэрхангай сум/ төсөл, арга хэмжээний өмнөх гүйцэтгэгч "Бэржин-Урьт" ХХК-нд 200.0 сая төгрөг буюу 44.3 хувийн санхүүжилт олгосон байхад барилга угсралтын ажлын гүйцэтгэл 15 хувьтай гэрээ цуцлагдсан байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгийг шамшигдуулах эрсдэлтэй бөгөөд захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан барилга угсралтын ажлын гэрээний Ерөнхий нөхцөлийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 5.4-т "Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагад тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх ..." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл, арга хэмжээний өмнөх гэрээг дүгнэж, акт үйлдэн улсын төсвөөс илүү төлсөн санхүүжилтийн зөрүүг нэхэмжлэх,
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр ашиггүй болгосон шалтгааныг тодруулж, холбогдох этгээдэд хариуцлага тооцох.
3. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганцэцэг, Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга Д.Нарантуяа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Өнөболд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТОР

М.ДАВААНЯМ

Б.ХАШ-ӨРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ӨНӨБОЛД

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 03 дугаар сарын 29

№ 01/103

Улаанбаатар хот

ГАГ 2018/02-ГА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дараах зөрчил илэрлээ.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн био устгалын III шатлалын лабораторийн барилга, гадна дулааны шугамын ажлын экспертизээр хянагдсан төсөв 10,383,831,841.0 төгрөг, гэрээний дүн 10,784,607,447.0 төгрөг буюу хяналтын төсвөөс 400,775,606.0 /дөрвөн зуун сая долоон зуун далан таван мянга зургаан зуун зургаа/ төгрөгөөр илүү байна. Энэ нь Төрийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана." гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх ..." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн био устгалын III шатлалын лабораторийн барилга угсралтын ажлын гэрээний дүнг хяналтын төсөвт тулгаж 400,775,606.0 /дөрвөн зуун сая долоон зуун далан таван мянга зургаан зуун зургаа/ төгрөгөөр бууруулж байгуулах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганцэцэг, Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга Д.Нарантуяа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Өнөболд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, БӨГӨӨД ТЭРҮҮЛЭХ
АУДИТОР
[Signature]
М.ДАВААЧИМ
АУДИТОР
[Signature]
Б.ХАШ-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ГАНЦЭЦЭГ
ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
[Signature]
Д.НАРАНТУЯА
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА
[Signature]
Д.ӨНӨБОЛД

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллага тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууллага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.